



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

IY.2.ХЭЛЭЛЦСЭН нь: “Улсын төсвийн санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулсан “Их Цогчин Дуган”-ын барилга, тоног төхөөрөмжийн ашиглалт, эзэмшлийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 05 дугаар тэмдэглэлд дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, албан тушаалтанд даалгасан:

1. Төрийн өмчийн “Их Цогчин Дуган”-ын барилга, байгууламжийг Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлийн хийд (шашны байгууллага)-д үнэ төлбөргүй ашиглуулах боломжийг судлан зохих арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т,

2. Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан Их Цогчин Дуган”-ын барилга, байгууламжийг Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлийн хийд (шашны байгууллага)-ийн эзэмшилд зохих журмын дагуу шилжүүлэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судалж, танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Соёлын сайд Ч.Номин, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт.”

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Улсын төсвийн санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулсан “Их Цогчин Дуган”-ын барилга, тоног төхөөрөмжийг Соёлын яамны эргэлтийн хөрөнгийн “хөрөнгө оруулалтын зориулалттай үндсэн хөрөнгө” дансанд хуримтлуулан бүртгэхийг зөвшөөрөв;

2. Төрийн өмчийн “Их Цогчин Дуган”-ын барилга, байгууламжийг Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлийн хийд (шашны байгууллага)-д үнэ төлбөргүй ашиглуулахыг зөвшөөрөв;

3. Ашиглалтын гэрээ байгуулан ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Дэлгэрмаа)-т зөвшөөрөв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132320212
4-r huraldaan.docx